

Баримт бичиг нягтлан шалгах комиссын
бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2013 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн Дүүргийн архивын үлгэрчилсэн дүрмийг батлах тухай А/451 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк” ОНӨТҮГазрын Баримт бичиг нягтлан шалгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Комиссын дарга	Б.Мичид-Эрдэнэ
Гишүүд	Ахлах мэргэжилтэн Б.Долгион Хөрөнгө оруулалт, төлөвлөлт хариуцсан эдийн засагч, хүний нөөцийн мэргэжилтэн Б.Мөнгөнхуяг Дэд бүтэц хариуцсан инженер Л.Оюунцэцэг Нягтлан бодогч
Нарийн бичгийн дарга	М.Мөнхдулам Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн

2. Баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрмийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, байгууллагын архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгож, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Баримт бичиг нягтлан шалгах комиссын дарга /Б.Мичид-Эрдэнэ/, нарийн бичгийн дарга /М.Мөнхдулам/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.ЭЛБЭГСАЙХАН

